

КАЛИФОРНИЙН ИХ СУРГУУЛЬ, САН-ФРАНЦИСКО

ТУРШИЛТАД ОРОЛЦОГЧИЙН

ЭРХИЙН ТУНХАГЛАЛ

Доорхи эрхүүд нь судалгаанд оролцохыг хүссэн хүн бүрийн эрх юм. Туршилтад оролцогчийн хувьд би дараах эрхийг эдэлнэ:

- 1) Судалгаагаар юу олж тогтоох гэж байгааг мэдэх,
- 2) Надад юу тохиолдох мөн аливаа ажиллагаа, эм, буюу төхөөрөмж стандарт эмчилгээнд хэрэглэдгээс өөр эсэхийг мэдэх,
- 3) Байнга тохиолддог ба/буюу гол эрсдэл, гаж нөлөө, буюу судалгааны үеэр надад тохиолдох зүйлийн зовиурыг мэдэх,
- 4) Судалгаанд оролцсоноор надад ямар нэгэн ашиг тустай байх эсэх, хэрэв тийм бол ямар ашиг тустайг мэдэх,
- 5) Надад байгаа бусад сонголт, эдгээр сонголт нь судалгаанд оролцсоноос хэр сайн буюу муу байхыг мэдэх,
- 6) Судалгаанд оролцохыг зөвшөөрөхөөсөө өмнө буюу судалгааны явцад судалгаатай холбоотой ямар ч асуулт тавих боломжтой байх,
- 7) Аливаа нэгэн хүндрэл гарсан тохиолдолд ямар эмчилгээ хийхийг мэдэх,
- 8) Судалгаанд оролцохоос бүр татгалзах буюу судалгаа эхэлсний дараа оролцох санаагаа өөрчлөх. Энэ шийдвэр нь миний судалгаанд оролцоогүйгээр бол хийлгэх байсан эмчилгээ сувилгаагаа хийлгэх эрхэд нөлөөлөхгүй,
- 9) Гарын үсэг зурж, он сар өдөр тавьсан зөвшөөрлийн маягтын хуулбарыг хүлээн авах,
- 10) Судалгаанд оролцох эсэхээ шийдэхэд дарамтгүй байх.

Надад өөр асуух зүйл байвал, эрдэм шинжилгээний ажилтан буюу туслах ажилтнаас асууна. Үүний зэрэгцээ, судалгааны төсөлд сайн дураар оролцогчдыг хамгаалах асуудлыг хариуцсан Хүн дээр хийх судалгааны хороонд хандаж болно. Би Даваа гарагаас Баасан гараг хүртэл 8:00 - 17:00 цагын хооронд хороо руу (415) 476-1814 дугаарын утсаар ярих буюу Committee on Human Research, Box 0962, University of California, San Francisco, CA 94143 хаягаар захидал бичин хандаж болно.

Орчуулгын талаар мэдээлэл хүсвэл 476-1814 руу залга.